



## НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

### Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн "Нийслэлийн 375 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө, төсвийг батлах тухай" 75 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын "Нийслэлийн 375 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хөрөнгө гаргах тухай" 2014 оны А/766 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад аялал жуулчлалын салбар үүсэж хөгжсөний 60 жилийн ой, Улаанбаатар хотын 375 жилийн ойд зориулсан "Найрсаг – Улаанбаатар" зөвлөгөөнийг Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Соёл урлагийн газар, Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар, Улаанбаатар чуулгатай хамтран зохион байгуулсугай.

2. "Найрсаг – Улаанбаатар" зөвлөгөөнийг хамтран зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. "Найрсаг – Улаанбаатар" зөвлөгөөнийг хамтран зохион байгуулахад шаардагдах 2.450.000 /хоёр сая дөрвөн зуун тавин мянга/ төгрөгийг батлагдсан удирдамж, төсвийн дагуу биеийн тамирын арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500107